

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсгийг тус тус үндэслэн “Мандал голомт” ХХК-иас ирүүлсэн хүсэлтийг хянан хэлэлцээд Эрчим хүчний зохицуулах хорооноос **ТОГТООХ нь:**

1. Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Батлагдсан тарифыг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Мандал голомт” ХХК /Н.Ганбаатар/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ тариф, зах зээлийн газар /Б.Болор-Эрдэнэ/-т даалгасугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 225 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

А.ТЛЕЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ

Э.ТҮВШИНЧУЛУУН

ЗОХИЦУУЛАГЧ

Б.БАТТУЛГА

ЗОХИЦУУЛАГЧ

У.МЯГМАРСҮРЭН

ЗОХИЦУУЛАГЧ

Э.САМДАН

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЕСӨНБУЛАГ СУМЫН ХЭРЭГЛЭГЧДЭД
БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

1. Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах хязгаарт багтаан тогтооно:

№	Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/	
1	Төсөвт байгууллага болон үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалт	Төг/ГДж	25,078.20	
		Төг/м ³	2,070.00	
2	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, "О"-ын өрөөний халаалт хамаарна)	Төг/м ²	560.00	
3	Дулааны үйлчилгээний тариф	40 хүртэл м ² талбайтай айл өрх	Төг/сар	3,000.00
		41 м ² -аас 80 м ² хүртэл талбайтай айл өрх	Төг/сар	5,000.00
		81 м ² -аас дээш талбайтай айл өрх	Төг/сар	10,000.00